

ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ, ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 2,341.7 сая ам.доллар байлаа.

2012 оны 3 дугаар сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 2,341.7 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 28.0%-иар өсчээ. Нийт бараа эргэлтийн 47.1% буюу 1,101.7 сая ам.долларын худалдааг Хятад улстай, 20.1% буюу 470.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна.

Импортын хурдтай өсөлт хадгалагдсаар...

Тайлант хугацаанд нийт экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.1%-иар өсч 883.8 сая ам.долларт, импорт 34.0%-иар өсөн 1,457.9 сая ам.долларт тус тус хүрчээ. Импортын өсөлтийн хурд экспортынхоос 1.8 дахин илүү байснаар нийт гадаад худалдааны алдагдал 574.1 сая ам.долларт хүрэв. Үүнээс валютаар төлбөр нь хийгддэг барааны гадаад худалдааны алдагдал 332.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2.3 дахин өсөөд байна.

Гадаад худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт 3 дугаар сард сөрөг байлаа.


2012 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс¹ 1.498-д хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.0%-иар буурлаа. Гадаад худалдааны нөхцөлийн индексийн бууралтад нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/

	Эхний 3 сар		Δ%
	2011	2012	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	1,830.0	2,341.7	28.0%
▪ Валютын төлбөртэй бараа	1,601.5	2,097.6	31.0%
Экспорт	742.1	883.8	19.1%
▪ Валютын төлбөртэй бараа	729.0	882.6	21.1%
Импорт	1,087.8	1,457.9	34.0%
▪ Валютын төлбөртэй бараа	872.5	1,215.1	39.3%
Гадаад худалдааны тэнцэл	-345.7	-574.1	1.7x
▪ Валютын төлбөртэй бараа	-143.5	-332.5	2.3x

Эх сурвалж: ГЕГ

Зураг 1. Гадаад худалдааны эргэлт, сараар /сая ам.доллар/




Эх сурвалж: ГЕГ

Зураг 2. Худалдааны нөхцөлийн индекс, сараар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА, ТҮҮХИЙ ЭД²

¹ Экспортод дунджаар 90 орчим хувийг эзэлдэг 10 бүтээгдэхүүн, импортод дунджаар 88 орчим хувийг эзэлдэг 7 бүлэг бүтээгдэхүүний хувьд худалдааны нөхцөлийн индексийг 2000 оныг суурь болгон тооцов.

² Экспортын үнэ нь худалдааны түнш хооронд гэрээгээр тохирсон болон бүс нутгийн зах зээл дэх үнийг илэрхийлнэ.

Чулуу нүүрсний экспорт нийт экспортын 40.6 хувийг бүрдүүлж байна.

2012 оны 3 дугаар сарын байдлаар 883.8 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 19.1% буюу 141,7 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Мөн хугацаанд нийт экспортын 40.6%-ийг чулуу нүүрс, 22.5%-ийг зэсийн баяжмал, 12.2%-ийг төмрийн хүдэр ба баяжмал, 8.5%-ийг боловсруулаагүй нефть тус тус бүрдүүлж байна. Тус хугацаанд “Бороо Гоулд” ХХК 472.0 кг алтыг Канад улсад экспортолсон байна.

Цайрын хүдэр ба баяжмал, мөнгөжөөгүй алт, жоншны экспортын биет хэмжээ буурснаар нийт экспорт 24,7 сая ам.доллараар буурахаар

байсан боловч (i) чулуун нүүрс ii) төмрийн хүдэр ба баяжмал, (iii) боловсруулаагүй нефтьний биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан 95.3 сая ам.доллараар, эдгээр бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний экспортын үнийн өсөлтөөс шалтгаалан 69.9 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс өсөхөд нөлөөлжээ.

Экспортын түүхий эдийн үнэ буурч байна.

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2012 оны 3 дугаар сарын 30-ны өдөр унц тутамд 1663.6 ам.долларт хүрсэнээр өнгөрсөн оны мөн үеэс 16%-иар өссөн боловч өмнөх сараас 6.7%-иар буурсан байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2012 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 8474.5, 1995.0 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 10%, 15%-иар, өмнөх сараас тус тус 0.2% ,4.6%-иар буурсан байна.

Зураг 5. Лондонгийн металлын бирж дэх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ /ам.доллар/



Эх сурвалж: Bloomberg


Өвөрмонголын зах зээл дэх нүүрсний дундаж үнэ 2012 оны 3 дугаар сарын байдлаар тонн тутамд 113.1 ам.долларт хүрч оны эхнээс 7 хувиар өссөн байна. Харин Монгол Улсын экспортын нүүрсний хилийн дундаж үнэ тонн тутамд 109.4 ам.долларт хүрч өмнөх сараас 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 3 сар				Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар/
	2011 Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	2012 Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	
1 Чулуун нүүрс	2,918,515	201.7	3,279,224	358.8	77.9% ↑
2 Зэсийн баяжмал	138,149	241.7	140,134	198.6	-17.8% ↓
3 Төмрийн хүдэр ба баяжмал	909,895	75.3	1,478,607	107.7	43.1% ↑
4 Боловсруулаагүй нефть	498,986	46.3	750,247	75.4	62.9% ↑
5 Цайрын хүдэр ба баяжмал	40,049	48.2	31,453	30.3	-37.2% ↓
6 Мөнгөжөөгүй алт	832	32.8	472	20.8	-36.6% ↓
7 Жонш, лейцит, нефелин ба нефелин	89,479	17.3	88,747	19.2	10.6% ↑
8 Молибдений хүдэр ба баяжмал	1,010	12.4	1,063	10.1	-18.7% ↓
9 Ямааны угаасан ноолуур	38	2.2	24	0.9	-57.3% ↓
10 Ямааны самансан ноолуур	16	1.5	89.5	8.1	431.4% ↑
Бусад		62.7		53.8	-14.2% ↑
Нийт экспорт		742.1		883.8	19.1% ↑

Эх сурвалж: ГЕГ

Зураг 4. Экспортын өөрчлөлт дэх үнийн болон тоо хэмжээний нөлөөлөл /сая ам.доллар/



Эх сурвалж: ГЕГ

Зураг 6. Чулуун нүүрсний зах зээлийн үнэ /ам.доллар/



Эх сурвалж: ГЕГ, ЭБЭХЯ

Импортын өсөлт үргэлжилсээр...

2012 оны 3 дугаар сарын байдлаар нийт импорт 1,457.9 сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 34.0 хувиар буюу 370.1 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд: i) нефтийн импорт 1.9 дахин өсч 352.4 сая ам.долларт, ii) хүнд машин, механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт 1.2 дахин өсч 241.3 сая ам.долларт тус тус хүрсэн нь голлон нөлөөлжээ.

Нийт импортын 83.3% буюу 1,215.1 сая ам.долларыг валютын төлбөртэйгээр, 14.2% буюу 206.4 сая ам.долларыг хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа эзэлж байна.

Зураг 7. Монгол улсын нефтийн импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: ГЭГ

Хүснэгт 3. Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Нэр төрөл	Эхний 3 сар		Өөрчлөлт /хувиар/
	2011	2012	
1 Нефтийн бүтээгдэхүүн	183.1	352.4	92.4% ↑
2 Тээврийн хэрэгсэл	214.1	224.1	4.6% ↑
3 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	200.3	241.3	20.4% ↑
4 Хүнсний бүтээгдэхүүн	35.8	41.9	17.3% ↑
6 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	34.5	46.8	35.6% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	14.8	24.4	64.3% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	2.5	6.5	159.1% ↑
8 Төрөл бүрийн даавуу	0.3	0.2	-12.0% ↓
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	38.7	47.9	23.5% ↑
Бусад	363.6	472.5	29.9% ↑
Нийт импорт	1,087.8	1,457.9	34.0% ↑

Нефтийн хилийн дундаж үнэ хэлбэлзэлтэй байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын нефтийн импортын биет хэмжээ өнгөрсөн оноос 44.8%-иар, хилийн дундаж үнэ 32.7%-иар тус тус өссөнөөр нийт нефтийн импорт мөнгөн дүнгээр 352.4 сая ам.долларт хүрчээ.

Нефтийн импортын хилийн дундаж үнэ 2012 оны 3 дугаар сард тонн тутамд 1237.5 ам.долларт хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 33.9%-иар, өмнөх сараас 0.7%-иар өссөн байна.

Зураг 8. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ



Эх сурвалж: Bloomberg

Дүгнэлт: Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2012 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 42.4%-иар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 11.8%-иар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 43.8%-иар өссөн нь голлон нөлөөлөв.